

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Монгол улс дахь төрийн бус байгууллагуудын мэдээлэл

Судалгааны тайлан

Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар
Ардчиллын Боловсрол Төв гүйцэтгэв.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

1. Монгол дахь ТББ-уудын суурь мэдээлэл	3
2. Аргачлал	5
3. ТББ-уудын бүртгэл	6
4. ТББ-уудын төрөл ба хэлбэр	8
5. ТББ-уудын байршлын тархалт	10
6. ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл	11
7. ТББ-уудын бүтэц	13
8. ТББ-уудын татвар төлөлт	17
9. ТББ-уудын тайлан	23
10. ТББ-уудын санхүүжилт	25
11. Хавсралт	28
1) ХЗДХЯ-нд бүртгүүлсэн ТББ-ын жагсаалт	
2) Судалгаанд хамрагдсан ТББ-уудын мэдээллийн сан	
3) Татварын албадад бүртгэлтэй ТББ-ын жагсаалт	



1. МОНГОЛ ДАХЬ ТББ-УУДЫН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

- 2005 оны 09-р сарын 01-ний байдлаар Хууль зүй дотоод хэргийн яаманд 5077 ТББ бүртгэгдсэн байна.
- 1997- 2004 оны байдлаар ХЗДХЯ-нд бүртгүүлсэн ТББ-уудын тоог авч үзвэл, жилд дунджаар 560 ТББ үүсгэн байгуулагдсан байна. Энэ нь дунджаар сард 50 ТББ, 7 хоногт 12 ТББ бүртгүүлсэн байна.
- Ихэнхи ТББ-ууд “ТББ-ын тухай хууль” батлагдсаны дараа буюу 1997 оноос хойш байгуулагдсан. ТББ-уудын 40 гаруй хувь нь 2002-2004 онуудад ХЗДХЯ-нд бүртгүүлжээ.
- ХЗДХЯ-нд бүртгэгдсэн ТББ-уудаас 80 гаруй хувь нь нийгэмд үйлчилдэг ТББ, 20 орчим хувь нь гишүүддээ үйлчилдэг гэж бүртгүүлсэн байна.
- Нийт ТББ-уудын 50 гаруй хувь буюу 1562 нь холбоо, нийгэмлэг гэсэн хэлбэрээр бүртгүүлсэн байна. Бусад хэлбэрүүдийн хувьд 627 төв, 514 сан, 231 клуб багтаж байна. Түүнчлэн 74 зөвлөл, 45 академи, 41 хороо, 39 хөдөлгөөн, 27 товчоо зэрэг хэлбэрээр бүртгүүлсэн байна.
- Татварын албанд тушаасан ТББ-уудын тайлан мэлээллээс үндэслэж гаргасан тооцоогоор нийт ТББ-уудын 20 хүрэхгүй хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэсэн дүр зураг харагдаж байна.
- Нийт ТББ-уудын 77% нь УБ хотод байрладаг ба 23% нь хөдөө орон нутагт ажиллаж байна.
- Нийслэлийн хэмжээгээр Сүхбаатар дүүрэгт 307 ТББ, Чингэлтэй дүүрэгт 217 ТББ татварын албадад бүртгэлтэй байгаа нь тухайн дүүргүүд хамгийн олон ТББ-тайд тооцогдож байна. Харин хөдөө орон нутгийн хувьд Дархан-Уул аймагт 36 ТББ, Дундговь аймагт 29 ТББ татварын албадад бүртгүүлсэн байна.
- 2002-2004 оны байдлаар ХЗДХЯ-нд үйл ажиллагааны жилийн тайлангаа ирүүлсэн ТББ-ууд тоо нийт бүртгэгдсэн ТББ-ын 5%-ийг эзэлж байна.
- Нийт ТББ-уудын 13,4% нь хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, бизнес, 11,8% нь спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг, 11,0% нь нийгмийн асуудал гэсэн салбаруудыг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээр тодорхойлжээ.
- Хүний нөөцийн хувьд нийт ТББ-ын ойролцоогоор 30% нь 2 үндсэн ажилтантай, 23,5% нь 5 ажилтантай, 17,6% нь 3 ажилтантай байна.

- ТББ-уудын Удирдах Зөвлөлийн гишүүдийн тоог авч үзвэл ТББ-уудын 47% нь 5 Удирдах зөвлөлийн гишүүнтэй, 22% нь 9 УЗ-ийн гишүүнтэй, 17% нь 7 гишүүнтэй байна.
- Нийт холбоо, нийгэмлэгийн тэн хагас нь 50-иас илүүгүй гишүүдтэй, 25% нь 50-100 гишүүдтэй байхад 2 орчим хувь нь 100-аас дээш гишүүдтэй байгууллагууд байна.
- Гишүүнчлэлтэй ТББ-уудын 50 орчим хувь нь гишүүнчлэлийн татвартай бөгөөд татварын хэмжээ нь 100-500.000 төгрөгийн хэлбэлзэлтэй байна.
- 2004 оны байдлаар ТББ-уудын санхүүжилтийн байдлыг авч үзвэл 59.5% нь гадаадын донор байгууллагууд, 27.9% - өөрсдийн үйл ажиллагааны орлого, 12.6% - хандив, дэмжлэг гэсэн эх үүсвэрүүдээс бүрдсэн байна.
- ТББ-ууд 2002-2004 онуудад улсын төсөвт нийт 2, 851.5 сая төгрөгийн татвар төлсөн байна.
- ТББ-ууд 2002 онд 19,1 сая төгрөг, 2003 онд 34,5 сая төгрөг, 2004 онд 26,7 сая төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлжээ.
- 2001 - 2005 онуудад төрийн сангаас 17 ТББ нийт 156, 6 сая төгрөгийн тэтгэлэг болон гэрээгээр ажил гүйцэтгэсэн байна.

2. АРГАЧЛАЛ

“Монгол дахь ТББ-уудын дүр зураг” судалгаа нь тоон үзүүлэлтийн судалгаа бөгөөд Хууль зүй дотоод хэргийн яам, Үндэсний татварын ерөнхий газар болон Татварын албадуудаас авсан мэдээлэл дээр үндэслэн хийсэн болно. Судалгааны мэдээ, мэдээллийг 2005 оны 07-р сарын 01-нээс 12-р сарын 15-ны хооронд цуглуулж нэгтгэсэн.

Уг судалгааг дараах аргачлалаар явуулав. Үүнд:

1) ТББ-уудын бүртгэл ба ТББ-уудын жилийн тайлан:

- ХЗДХЯ дахь ТББ-уудын бүртгэл болон ТББ-уудын жилийн тайлантай холбогдолтой бичиг баримттай нэг бүрчлэн танилцах, хэрэгцээт мэдээ мэдээллийг цуглуулах.

2) ТББ-уудын санхүүгийн ба татварын тайлан:

- Татварын албадуудад дахь ТББ-уудын бүртгэл, санхүүгийн болон татварын тайлантай нэг бүрчлэн танилцах, хэрэгцээт мэдээ, мэдээллийг цуглуулах.

2005 оны 9-р сарын 1-ний байдлаар ХЗДХЯ-нд 5077 ТББ бүртгэлтэй байсан. Үүнээс 3720 ТББ энэхүү судалгаанд хамрагдсан болно.

Татварын байгууллагуудад бүртгэлтэй ТББ-уудын тоон мэдээллийг Үндэсний татварын газар болон дүүргүүдийн татварын албадаас авсан бөгөөд 2005 оны 8-р сарын 1-ний байдлаар 1042 ТББ татварын албадад бүртгэлтэй байв.

Уг судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулахад ХЗДХЯ болон Үндэсний татварын ерөнхий газрын холбогдох ажилтан, албан тушаалтнууд дэмжлэг үзүүлж судалгааны багтай хамтран ажилласан юм.


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3. ТББ-УУДЫН БҮРТГЭЛ

ТББ-уудын бүртгэлийн тоог ХЗДХЯ-ны бүртгэлийн жагсаалтанд орсон ТББ-уудын тоонд дээр суурилсан бөгөөд 2005 оны 09-р сарын 01-ний байдлаар албан ёсоор бүртгүүлсэн ТББ-ын тоо 5077 байв.

Доорхи Диаграмм 1-д үзүүлсний дагуу ТББ-уудын бүртгэл нь жилээс жилд өсөх хандлагатай байна. ХЗДХЯ нь зөвхөн шинээр үүсгэн байгуулагдаж буй ТББ-уудыг бүртгэдэг бөгөөд татан буулгасан ТББ-уудын бүртгэл байдаггүй байна.

Диаграмм 1.



1997 онд ТББ-ын тухай хууль батлагдсанаар 1998 онд 600 гаруй ТББ бүртгүүлсэн байна. Үүнээс хойшхи жилүүдэд, ялангуяа 2000 - 2003 онуудад ТББ-уудын бүртгүүлэх байдалд алгуур багасах хандлагатай байсан.

Сүүлийн 3 жил буюу 2003-2005 онуудад шинээр бүртгүүлсэн ТББ-уудын тоо нилээд өссөн байна. 2004 онд хамгийн их буюу 988 ТББ бүртгүүлсэн байна.

1997- 2004 оны байдлаар ТББ-ын бүртгүүлсэн байдлыг авч үзвэл жилд дунджаар 560 ТББ бүртгүүлсэн байна. Энэ нь сард ойролцоогоор 50 ТББ буюу 7 хоногт 12 ТББ ХЗДХЯ-нд бүртгүүлсэн байна.

4. ТББ-УУДЫН ТӨРӨЛ БА ХЭЛБЭР

ТББ-ын төрөл

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4-р зүйлд төрийн бус байгууллагын төрлийг “нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага”, “гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага” гэж заасан байдаг. Нийгэмд үйлчилдэг ТББ нь соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг хэлнэ. Гишүүддээ үйлчилдэг ТББ нь өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад байгууллага байдаг.

ТББ нь бүртгүүлэхдээ өөрсдөө дээрх 2 төрлийн алин болохоо дүрэмдээ тодорхойлон заасан байдаг ба үүний дагуу улсын бүртгэлд бүртгэдэг.

Судалгаанд хамрагдсан 3720 ТББ-ын дийлэнх нь “нийгэмд үйлчилдэг” төрлөөр бүртгэгдсэн байна. Нийт ТББ-уудын 80 гаруй хувьтай тэнцэх буюу 3158 ТББ “нийгэмд үйлчилдэг” гэж бүртгүүлжээ. Харин нийт ТББ-уудын бараг 20% буюу 742 ТББ “гишүүддээ үйлчилдэг” хэмээн бүртгэгдсэн байна.

ТББ-ын хэлбэр

ХЗДХЯ-аас цуглуулсан мэдээ, мэдээлэлд суурилан 19 хэлбэрийн ТББ байгааг олж тогтоолоо. 1,562 ТББ холбоо, нийгэмлэг гэсэн хэлбэрээр бүртгүүлсэн байгаа нь судалгаанд хамрагдсан нийт ТББ-уудын бараг 50%-тай тэнцэж байгаа юм. Дараах олонхид 627 төв, 514 сан, 231 клуб гэсэн хэлбэрүүд орж байхад үлдсэн хэсгийг 74 зөвлөл, 45 академи, 41 хороо, 39 хөдөлгөөн, 27 товчоо зэрэг бүрдүүлж байна (дараах Хүснэгт 1 болон Диаграмм 2-ыг үзнэ үү).

Хүснэгт 1.


ТББ-ын хэлбэрүүд /хувиар/

№	ТББ-ын хэлбэр	ТББ-ын тоо	%
1	Холбоо, нийгэмлэг	1562	47.8
2	Төв	627	19.2
3	Сан	514	15.7
4	Клуб	261	8.0
5	Зөвлөл	74	2.3
6	Академи	45	1.4
7	Хороо	41	1.3
8	Хөдөлгөөн	39	1.2

9	Товчоо	27	0.8
10	Сүлжээ байгууллага	18	0.6
11	Хүрээлэн	13	0.4
12	Улс төрийн намын салбар	11	0.3
13	Дээвэр байгууллага	9	0.3
14	Групп	8	0.2
15	Хоршоо	6	0.2
16	Консорциум	5	0.2
17	Агентлаг	4	0.1
18	Танхим	3	0.1
19	Сонин	3	0.1
	Нийт	3270	100.0

Диаграмм 2.

ТББ-ын хэлбэрүүд /тоогоор/




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5. ТББ-УУДЫН БАЙРШЛЫН ТАРХАЛТ

ХЗДХЯ-наас авсан ТББ-уудын мэдээллээс үзэхэд бүртгүүлсэн нийт ТББ-ын 90% нь УБ хотод, 10% нь хөдөө орон нутагт байрлалтай байна. Хөдөө орон нутагт салбартай 91 ТББ ажиллаж байна. Диаграмм 3-т ТББ-ын тархалтын байдлыг нийслэл хот, аймаг, орон нутгуудад эзлэх хувиар харууллаа. ТББ-ын тоо нилээд өндөр байгаа газруудад дараах аймгууд байна. Үүнд: Дархан-Уул аймагт ТББ-ын тархалтын хувь 3.5, Дундговь аймагт 2.8%, Орхон аймагт 2.4%, Завхан аймагт 2.1%-тай байна. ТББ-ын тоо нь бага хувьтай аймгуудад Баянхонгор 1.6%, Дорнод 1.4%, Өвөрхангай ба Хөвсгөл тус бүр 1.1% орж байна.


Диаграмм 3.



6. ТББ-УУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Судалгаанд хамрагдсан нийт 3720 ТББ-ын дүрмэндээ заасан үйл ажиллагааг авч үзэхэд ойролцоогоор 21 чиглэлд ангилж болохоор байна. Диаграмм 4-т ТББ-уудын үйл ажиллагааны чиглэлийг харуулав.

Диаграмм 4.



ТББ-ын үйл ажиллагааны чиглэлийг тоо ба эзлэх хувиар Хүснэгт 2-т үзүүлэв. Нийт ТББ-уудын 13,4% нь хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, бизнес, 11,8% нь спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг, 11,0% нь нийгмийн асуудал, 8,8% нь мэргэжлийн холбоод, 8,7% нь урлаг, соёл, уламжлалт ёс, шинжлэх ухаан гэсэн салбаруудыг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гэж тодорхойлжээ.

Хүснэгт 2.

ТББ-ын ангилал / тоо ба эзлэх хувиар/

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Тоо	Эзлэх хувь
1	Эдийн засаг, ХАА, бизнес	500	13.4
2	Спорт, аялал жуулчлал, чөлөөт цаг	441	11.8
3	Нийгмийн асуудал	410	11.0
4	Мэргэжлийн холбоод	329	8.8
5	Соёл, урлаг, уламжлалт ёс, ш/ухаан	325	8.7
6	Хүүхэд, залуучууд	245	6.6
7	Экологи, байгаль орчин	243	6.5

8	ОУ-ын хамтын ажиллагаа	230	6.2
9	Орон нутгийн хөгжил	196	5.3
10	Боловсрол	183	4.9
11	Эрүүл мэнд	154	4.1
12	Эмэгтэйчүүд, гэр бүл	104	2.8
13	Хүний эрх, ардчилал	97	2.6
14	Ахмад настан	60	1.6
15	Мэдээллийн технологи	45	1.2
16	Хууль, эрх зүй	44	1.2
17	Хэвлэл мэдээлэл	43	1.15
18	Шашин шүтлэг	43	1.15
19	Судалгаа	11	0.30
20	Улс төрийн намын салбар	9	0.24
21	Батлан хамгаалах	8	0.22


7. ТББ-ЫН БҮТЭЦ

Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11.3-т “Удирдах Зөвлөл нь таваас доошгүй сондгой тооны гишүүдээс бүрдэнэ” гэж тусгажээ. Судалгаанаас үзэхэд ТББ-ууд дээрх заалтыг төдийлөн мөрдөөгүй байна. Тухайлбал, Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо тэгш байх тохиолдол байна.

ТББ-уудын Удирдах Зөвлөлийн гишүүдийн тоог авч үзвэл ТББ-уудын 47% нь 5 Удирдах зөвлөлийн гишүүнтэй, 22% нь 9 УЗ-ийн гишүүнтэй, 17% нь 7 гишүүнтэй байна. Үлдсэн 5% нь 11 гишүүнтэй, 3% нь 6 гишүүнтэй, 6 болон 15 гишүүнтэй тус бүр 2% байна.

Диаграмм 5.



Зарим ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдийн тоо нь анхаарал татаж байсан. Жишээлбэл, уг судалгаанд хамрагдсан байгууллагуудаас 1 Удирдах зөвлөлийн гишүүнтэй 6 ТББ, 2 гишүүнтэй 5 ТББ байхад нэг ТББ 312 УЗ-ийн гишүүнтэй гэж бүртгүүлсэн байна.


Удирдах зөвлөлийн бүтэц

ТББ-уудын удирдах зөвлөлийн гишүүдийн бүтцийн хувьд ТББ-ын төлөөлөл нь 28%, төр засгийн төлөөлөл 22%, бизнесийн салбарын төлөөлөл 16%, ЕБС болон их дээд сургуулийн багш нар 7%, олон улсын байгууллагын төлөөлөл 7%, улс төрийн намын гишүүд 5%, УИХ-ын гишүүд 3% гэсэн төлөөлөлтэй байна.

Диаграмм 6 нь ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдийн бүтцийг хувиар илэрхийлэн харуулж байна.

Диаграмм 6.

ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүдийн бүтэц (%)



Судалгаанд хамрагдсан 3720 ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүдээс 59 нь одоогийн УИХ-ын гишүүд байна. Тухайлбал, УИХ-ын гишүүн С. Оюун 13 ТББ, УИХ-ын гишүүн Т. Ганди 9 ТББ-ын УЗ-д гишүүний бүртгэлтэй байна. “Алтан гадас” Ассоциаци 11 УЗ-ийн гишүүдтэй бөгөөд бүгд УИХ болон Засгийн газрын өндөр албан тушаалтнууд байна. Үүнтэй адил “Эрх чөлөө төв” ТББ, “Зүүн Хойд Ази Нийгэмлэг”, “Архангайн Гончигдорж сан”, “Мөнхийн Дэмжлэг Сан” гэх мэт байгууллагуудын УЗ-ийн гишүүдийн тоонд УИХ болон Засгийн Газрын гишүүд орсон байна.

Гүйцэтгэх алба

ТББ-ын гүйцэтгэх албаны ажилтнуудын бодит тоог гаргахдаа ХЗДХЯ-нд өгсөн ТББ-уудын үйл ажиллагааны тайланг үндэслэсэн.

Судалгаанд хамрагдсан 555 байгууллагын тайлангаас үзэхэд 2002-2004 онуудад зөвхөн 17 ТББ өөрийн үндсэн ажилтнуудын талаарх тоо, мэдээгээ тайлагнасан байна. Энэхүү 17 ТББ-ын гүйцэтгэх албаны ажилтнуудын тоог авч үзэхэд 30 орчим хувь нь үндсэн 2 ажилтантай, 23.5% нь 5 ажилтантай, 17.6% нь 3 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна гэсэн үзүүлэлт гарч байна.

Хүснэгт 3.

ТББ-ын гүйцэтгэх алба / тоогоор, хувиар/

Гүйцэтгэх алба (хүнээр)	2002-2004	
	ТББ-ын тоо	%
7	2	11,8
6	1	5,9
5	4	23,5
3	3	17,6
2	5	29,4
1	2	11,8
Нийт	17	100,0

Хяналтын зөвлөл

ТББ-ын Хяналтын зөвлөлийн дүр зургийг тоо болон хувиар дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 4.

ТББ-ын хяналтын зөвлөлийн тоо

Он	Бүртгүүлсэн ТББ-ын тоо	Хяналтын зөвлөлийн тоо	%
1990-1997	448	156	34,8
1998	594	69	11,6
1999	435	167	38,4
2000	460	143	31,1
2001	446	79	17,7
2002	481	90	18,7
2003	637	100	15,7
2004	988	180	18,2
Нийт	4,489	984	21,9

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт ТББ-уудын 22% нь Хяналтын зөвлөлтэй байна.

Сайн дурынхан

2004 онд сайн дурынхантай ажилладаг 12 ТББ-ын дунд Ардчиллын Боловсрол Төвөөс судалгаа явуулсан байна. Уг судалгаагаар тухайн 12 ТББ-д нийтдээ 4478 сайн дурынхан ажилладаг гэсэн үзүүлэлт гарсан юм. ТББ-ын үйл ажиллагаанд оролцдог сайн дурынхны тоог дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 5.

ТББ-ын сайн дурынхны тоо

№	ТББ-ын нэр	Сайн дурынхны тоо
1	Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан	17
2	Монголын Хөдөлмөр Хамгаалал Хөдөлгөөн	5
3	Монголын мэтгэлцээний холбоо	157
4	Монголын Оюутны Холбоо	186
5	Ардчиллын Боловсрол Төв	18
6	Эмнести Интернэшнл	20
7	Толгойт ТББ	54
8	Орхон-21-р зуун ТББ	39
9	Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо	1,715
10	Тэгш мөр төв	2
11	Монголын Сайн Дурынхны Нийгэмлэг	2,230
12	Цусны төв	35
	Нийт	4,478

Дээрх судалгаанд хамрагдсан сайн дурынхныг насны ангиллаар авч үзсэнийг доорхи хүснэгт харуулж байна.

Хүснэгт 6.

Сайн дурынхны насны ангилал

Нас	СД-ны тоо	%
18 нас хүртэлх	313	7,0
19-27	1,197	26,7
28-35	1,020	22,8
36-50	1,733	38,7
50 наснаас дээш	215	4,8
Нийт	4,478	100,0

Гишүүнчлэлтэй байгууллагууд ба гишүүнчлэлийн татвар

Нийт холбоо, нийгэмлэгийн тэн хагас нь 50-иас илүүгүй гишүүдтэй, 25% нь 50-100 гишүүдтэй байхад 2 орчим хувь нь 100-аас дээш гишүүдтэй байгууллагууд байна. Гишүүнчлэлтэй ТББ-уудын 50 орчим хувь нь гишүүнчлэлийн татвартай бөгөөд татварын хэмжээ нь 100 - 500.000 төгрөгийн хэлбэлзэлтэй байна.

8. ТББ-ЫН ТАТВАР ТӨЛӨЛТ

Татварын албанд бүртгэгдсэн ТББ-ын тоо ба байршил

ТББ-ын татвар төлөлтийн тооцоог гаргахдаа Үндэсний Татварын Ерөнхий Газар болон Нийслэлийн дүүргүүдийн татварын албадад бүртгэлтэй ТББ-уудын мэдээнд үндэслэж гаргалаа. 2005 оны 08-р сарын 01-ний байдлаар татварын албадад нийт 1042 ТББ бүртгэгдсэн байна.

Татварын албадад бүртгэгдсэн ТББ-уудын тоог авч үзвэл Улаанбаатар хотын дүүргүүдийн татварын албанд бүртгэлтэй ТББ-ууд дийлэнх (76.6%) хувийг эзэлж байна. Үлдсэн 23.4% нь аймгуудын татварын албадуудад бүртгэлтэй байна.

Нийслэлийн хэмжээнд Сүхбаатар дүүрэгт 307 ТББ, Чингэлтэй дүүрэгт 217 ТББ татварын албадад бүртгэлтэй байгаа нь тухайн дүүргүүд хамгийн олон ТББ-тайд тооцогдож байна. Харин хөдөө орон нутгийн хувьд Дархан-Уул аймагт 36 ТББ, Дундговь аймагт 29 ТББ татварын албадад бүртгүүлсэн байна. Харин Сүхбаатар аймгийн татварын албанд ТББ бүртгүүлээгүй байна.

Хүснэгт 7.

Татварын албанд бүртгэлтэй ТББ-ын тоо (аймаг, дүүргүүдээр)

№	Татварын албадын байршил	Бүртгэлтэй ТББ-ын тоо	%
1	Архангай аймаг	9	0.9
2	Баян-Өлгий аймаг	1	0.1
3	Баянхонгор аймаг	17	1.6
4	Булган аймаг	11	1.1
5	Говь-Алтай аймаг	9	0.9
6	Говьсүмбэр аймаг	2	0.2
7	Дархан-Уул аймаг	36	3.5
8	Дорноговь аймаг	5	0.5
9	Дорнод аймаг	14	1.3
10	Дундговь аймаг	29	2.8
11	Өвөрхангай аймаг	11	1.1
12	Өмнөговь аймаг	8	0.8
13	Завхан аймаг	22	2.1
14	Орхон аймаг	25	2.4
15	Сэлэнгэ аймаг	9	0.9
16	Төв аймаг	9	0.9
17	Увс аймаг	6	0.6
18	Хөвсгөл аймаг	10	1.0

19	Ховд аймаг	9	0.9
20	Хэнтий аймаг	2	0.2
	Аймгуудын нийт дүн	244	23.4
1	Багануур дүүрэг	3	0.3
2	Баянгол дүүрэг	51	4.9
3	Баянзүрх дүүрэг	93	8.9
4	Нийслэлийн татварын газар	8	0.8
5	Налайх дүүрэг	1	0.1
6	Сүхбаатар дүүрэг	307	29.5
7	Сонгинохайрхан дүүрэг	47	4.5
8	Хан-Уул дүүрэг	71	6.8
9	Чингэлтэй дүүрэг	217	20.8
	УБ хотын дүүргүүдийн нийт дүн	798	76.6
	Нийт	1042	100

ТББ-уудын төлсөн татварын төрөл ба дүн

ТББ-ууд 2002-2004 онуудад улсын төсөвт 2,851.5 сая төгрөгийн татвар төлсөн байна. Хүснэгт 8-аас харахад Баянзүрх дүүргийн татварын албанд бүртгэлтэй ТББ-ууд нийтдээ 847,3 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн татварын албанд бүртгэлтэй ТББ-ууд 773,5 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн татварын албанд бүртгэлтэй ТББ-ууд 434, 1 сая төгрөгийн татварыг тус тус төлсөн байна.

Хүснэгт 8.

2002-2004 онд ТББ-уудын төлсөн татвар

(мянган төгрөгөөр)

№	Татварын албадын байршил	ТББ-ын тоо	2002-2004 онд төлсөн татвар (мян. төг)	%
1	Архангай аймаг	9	1,395.40	0.05
2	Баян-Өлгий аймаг	1	52.00	0.00
3	Баянхонгор аймаг	17	2,006.20	0.07
4	Булган аймаг	11	356.70	0.01
5	Говь-Алтай аймаг	9	254.60	0.01
6	Говьсүмбэр аймаг	2	45.90	0.00
7	Дархан-Уул аймаг	36	15,199.10	0.53
8	Дорноговь аймаг	5	7.50	0.00
9	Дорнод аймаг	14	3,036.70	0.11
10	Дундговь аймаг	29	9,940.00	0.35
11	Өвөрхангай аймаг	11	458.70	0.02
12	Өмнөговь аймаг	8	84.20	0.00

13	Завхан аймаг	22	2,945.40	0.10
14	Орхон аймаг	25	9,616.10	0.34
15	Сэлэнгэ аймаг	9	598.50	0.02
16	Төв аймаг	9	1,499.90	0.05
17	Увс аймаг	6	3,122.80	0.11
18	Хөвсгөл аймаг	10	17.40	0.00
19	Ховд аймаг	9	621.00	0.02
20	Хэнтий аймаг	2	45.10	0.00
	Аймгуудын нийт дүн	244	51,303.20	1.80
1	Багануур дүүрэг	3	0.00	0.00
2	Баянгол дүүрэг	51	48,883.30	1.71
3	Баянзүрх дүүрэг	93	847,261.00	29.71
4	Нийслэлийн татварын газар	8	580,568.20	20.36
5	Налайх дүүрэг	1	83.60	0.00
6	Сүхбаатар дүүрэг	307	773,468.90	27.12
7	Сонгинохайрхан дүүрэг	47	59,586.20	2.09
8	Хан-Уул дүүрэг	71	56,300.60	1.97
9	Чингэлтэй дүүрэг	217	434,057.20	15.22
	УБ хотын дүүргүүдийн нийт дүн	798	2,800,209.00	98.20
	Нийт	1042	2,851,512.20	100.00


ТББ-уудын улсын төсөвт оруулж татварын хэмжээ жилээс жилд өсөж байгаа үзүүлэлтийг дараах диаграммаас харж болно.

Татвар төлөлтийг төрлөөр нь авч үзэхэд Хүн амын орлогын албан татвар буюу Суутгал-1-ээр хийгдсэн татвар дийлэнх хувийг эзэлж байна.



Диаграмм 7.

**ТББ-ын төлсөн татвар
(тоон үзүүлэлтээр-мян.төг-өөр)**



Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн байдал

Татварын хуулинд ТББ-ын салбарын хөгжлийг дэмжих үүднээс ТББ-ын орлогыг татвараас чөлөөлөх хэд хэдэн заалт орсон байдаг. ААНБОАТ-ын хуулийн 7.1.2 болон 7.1.7-д заасны дагуу ТББ-ууд 2002 онд 19,1 сая төгрөг, 2003 онд 34,5 сая төгрөг, 2004 онд 26,7 сая төгрөгийн татварын чөлөөлөлтийг тус тус эдэлсэн байна.

Хүснэгт 9.

2002-2004 онд ТББ-ын татварын чөлөөлөлт

(мянган төгрөгөөр)

Он	ТББ-ын гишүүнчлэлийн татвар болон хандив, дэмжлэг (ААНБОАТ хуулийн 7.1.2-р зүйл)	Нийгэмд үйлчилдэг ТББ-ын орлого (ААНБОАТ хуулийн 7.1.7-р зүйл)	Татварын чөлөөлөлтийн дүн
2002	222.50	18,887.20	19,109.70
2003	14,020.60	20,506.30	34,526.90
2004	12,690.30	14,046.00	26,736.30
Нийт	26,933.40	53,439.50	80,372.90


Татвар төлөгч ТББ-уудын хэлбэрүүд

Татварын албаны бүртгэлээр татвар төлөгч ТББ-уудын хэлбэр нь ТББ-ын тухай хуульд үзаасан хэлбэрээс өөр байна. Татварын албанд бүртгэлтэй нийт 1042 ТББ-аас 75% нь төрийн бус байгууллагууд, 6,5% нь сургууль ба цэцэрлэг, 4,3% - сонин, 3,4% - банкуудын салбарууд, 2,8% - төлөөлөгчин газрууд, 2,4% - товчоо ба нотариат, 1,8% - Сууц өмчлөгчдийн холбоод, 0,8% - телевизийн студи, 0,6%- улс төрийн намууд, 2,4% нь бусад гэсэн байгууллагууд байна.

Дээрх байгууллагууд татварын албанд ашгийн бус гэсэн хэлбэрээр бүртгүүлсэн ч тухайн байгууллагуудын зарим хэсэг нь ашгийн хуваарилалт хийдэг байгууллагуул багтаж байна. Жишээ нь, хувийн сургууль ба цэцэрлэгүүд, банкуудын салбарууд, сонин болон телевизийн студиуд ашиг олохын төлөө байгуулагдсан байгууллагууд гэх мэт. Иймээс татварын албанд бүртгэлтэй ТББ-уудыг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэсэн зорилгоор нь дахин нарийвчилсан бүртгэл хийх шаардлагатай байна.

Диаграмм 8.

Татвар төлөгч ТББ-ын хэлбэрүүд




9. ТББ-ЫН ТАЙЛАН

ТББ-ын тухай хуулийн 5-р бүлгийн 23.2-т “Төрийн бус байгууллага нь зохих журмын дагуу жилийнхээ тайланг гаргаж дараа оны 2-р сарын 15-ны дотор ХЗДХЯ-нд гаргаж өгнө” гэж заасан байдаг.

Диagramм 9 -д ХЗДХЯ-нд тайлангаа ирүүлсэн ТББ-уудыг 2002-2004 оны байдлаар авч үзвэл ТББ-уудын үйл ажиллагааны тайлагналт яльгүй өсөх хандлага ажиглагдаж байна.

Диagramм 9.




Бүртгэлтэй нийт ТББ-уудын 5% нь үйл ажиллагааныхаа жилийн тайланг ХЗДХЯ-нд гаргаж өгдөг байна. Диagramм 10 нь ХЗДХЯ-нд үйл ажиллагааны тайлангаа ирүүлсэн ТББ-ууд болон бүртгүүлсэн нийт ТББ-уудын тоог харьцуулсан байдлаар харуулж байна.

ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

Диаграмм 10.

ХЗДХЯ-нд бүртгэлтэй ТББ ба Тайлангаа ирүүлсэн ТББ-ын харьцуулалт



1997 онд батлагдсан ТББ-ын хуулинд захиргааны хариуцлага хүлээлгэх тухай тусгасан бөгөөд ТББ-ын тухай хуулийн 6-р бүлэгт “Хуулинд заасан хугацаанд үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад гаргаж өгөөгүй бол гэм буруутай албан тушаалтныг 10,000-20,000 төгрөгөөр торгоно” гэсэн заалт байдаг. Дээрх диаграммын үзүүлэлтээр дунджаар 3,400 ТББ үйл ажиллагааныхаа жилийн тайланг ХЗДХЯ-нд ирүүлдэггүй гэж тооцоход тухайн байгууллагуудад жилд нийтдээ 51 сая төгрөгийн торгууль ногдуулах болж байна. Улмаар 3 жилийн хугацаанд 153 сая төгрөгийн торгууль төлөх тооцоо гарч байна.

ТББ-уудын ирүүлсэн нийт тайлангийн агуулга, тусгагдсан мэдээлэлтэй танилцахад тайлан бичих нэгдсэн аргачлал байхгүй, эмх цэгцгүй, тайлан гаргах олон улсын стандартад нийцээгүй болно. Жишээ нь, ихэнх тохиолдолд Гүйцэтгэх ажилтнуудын тоо, Удирдлагын бүтэц, Орлого ба зарлагын мэдээг тусгаж тайлагнаагүй байв.

2002 онд ХЗДХЯ-нд тайлангаа ирүүлсэн 178 ТББ байгаа бөгөөд үүнээс зөвхөн 63 ТББ нь тайлагнах стандартыг хангасан байна. Үүнтэй адилаар 2003 онд 182 ТББ-ын тайлангаас 34 тайлан, 2004 онд 198 тайлангаас 53 тайлан нь шаардлага хангасан байна.

10. ТББ-ЫН САНХҮҮЖИЛТ


ТББ-ын санхүүжилтийн эх үүсвэрүүд

Төрийн бус байгууллагын хуулийн 19-р зүйлд ТББ-ын орлогын эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- Гишүүний татвар ба хандив
- Иргэд, аж ахуйн нэгж болон бусад байгууллагын хандив
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого
- Зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө

2004 оны байдлаар ТББ-ууд нийт санхүүжилтийнхээ 59.5%-ийг гадаадын донор байгууллагуудаас, хувь хүн болон аж ахуйн нэгж байгууллагуудын хандиваас - 27.9%, үйл ажиллагааны орлогоосоо 12.6%-ийг тус тус олжээ¹.

Диаграмм 11.



Монголын ТББ-ууд ихэвчлэн гадаадын донор байгууллагуудын санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулдаг нь харагдаж байгаа боловч зарим ТББ-ууд өөрсдийн үйл ажиллагаанаас орлого олж эхэлж байна. Тухайлбал, сургалт, зөвлөгөө, хэвлэн нийтлэл, худалдаа, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө түрээслэх гэх мэтээр орлого олдог байна. Түүнчлэн ТББ-ууд дотоодын эх үүсвэрээс хөрөнгө босгох, хувь хүн болон бизнесийн салбараас ивээн тэтгэгчдийг эрэн сурвалжлах зэргээр орлогоо бүрдүүлж байна.

¹ Эх сурвалж: 2004 оны ТББ-уудын үйл ажиллагааны тайлан - ХЗДХЯ

Төрөөс ТББ-уудад олгосон санхүүжилт

ТББ-ын тухай хуулийн 9-р зүйлд “Төрөөс төрийн бус байгууллагын хууль ёсны эрхийг хамгаална”, “Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно” гэж заасан байдаг. Түүнчлэн Засгийн газрын тухай хуулийн 19-р зүйлийн 1-т “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасан байдаг. Энэхүү хуулийн дагуу 1995 онд Засгийн газрын 111-р тушаал гарч Засгийн газар нь холбогдох яамны сайдын тодорхойлолтын үндсэн дээр тухайн салбарын эрхлэх асуудлын хүрээний зарим чиг үүргийг гэрээгээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжилт олгох тухай шийдвэр гаргадаг юм байна.

Дараах хүснэгт нь 2001-2005 онуудад төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс ТББ-уудад олгосон хөрөнгө, төрийн тэтгэлгийн хэмжээг харуулж байна.

Хүснэгт 10.

Төрөөс тэтгэлэг авсан ТББ-уудын жагсаалт

N.	ТББ-ын нэр	Санхүүжилт(төгрөгөөр)					
		2001	2002	2003	2004	2005	Нийт
1.	Монголын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	11,848,000	0	10,500,000	7,500,000	10,500,000	40,348,000
2.	Монголын залуучуудын холбоо	20,000,000	0		1,200,000	0	21,200,000
3.	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо	2,000,000	8,000,000	3,700,000	1,150,000	3,500,000	18,350,000
4.	Монголын ардчилсан социалист залуучуудын холбоо	1,000,000	3,000,000	5,000,000	4,000,000	0	13,000,000
5.	Монголын ахмадын холбоо	5,000,000	0		2,800,000	3,500,000	11,300,000
6.	Монголын ардчилсан социалист эмэгтэйчүүдийн холбоо	3,000,000	0	2,500,000	2,500,000	0	8,000,000
7.	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	2,900,000	0	1,500,000	0	3,000,000	7,400,000
8.	Полиси судалгааны төв	0	6,259,000	0	0	0	6,259,000
9.	Монголын хараагүйчүүдийн	418,800	0	0	5,000,000	0	5,418,800

	нийгэмлэг						
10.	Гэр бүлийн боловсролын төв	0	0	0	0	5,000,000	5,000,000
11.	Тусламжийн Тэргэнцэр сан	706,800	1,500,000	1,000,000	1,500,000	0	4,706,800
12.	МАХН-ын ахмадын хороо	4,000,000	0	0	0	0	4,000,000
13.	Монголын эмэгтэйчүүдийн холбоо	0	0	2,400,000	1,200,000	0	3,600,000
14.	Монголын эрэгтэйчүүдийн холбоо	0	0	1,500,000	0	1,500,000	3,000,000
15.	“Өнөр бүл” сан	0	0	2,300,000	0	0	2,300,000
16.	Ахмадууд клуб	700,000	0	1,000,000	0	0	1,700,000
17.	Хүйсийн тэгш байдлыг хангах үндэсний зөвлөл	182,700	0	876,000	0	0	1,058,700
	Нийт	51,756,300	18,759,000	32,276,000	26,850,000	27,000,000	156,641,300

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТУУД

- 1) ХЗДХЯ-нд бүртгүүлсэн ТББ-ын жагсаалт
- 2) Судалгаанд хамрагдсан ТББ-уудын мэдээллийн сан
- 3) Татварын албадад бүртгэлтэй ТББ-ын жагсаалт